

## ТАНИЛЦУУЛГА

*Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгаа,  
цөмийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны  
холбогдолтой олон улсын конвенцуудын тухай*

Монгол Улс 1968 онд Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээнд гарын үсэг зурж, 1972 оноос хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн бөгөөд 1985 онд Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц, 1987 онд Цөмийн ослыг шуурхай мэдээлэх тухай конвенц, Цөмийн осол гарсан буюу цацрагийн аюултай байдал бий болсон тохиолдолд тусламж үзүүлэх тухай конвенц, 2006 онд Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай олон улсын конвенц, 2021 онд Цөмийн зэвсгийг хориглох тухай гэрээ зэрэг олон улсын хэд хэдэн гэрээ, конвенцид нэгдэн орж, олон улсын өмнө хүлээсэн үүргээ амжилттай биелүүлсээр байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат 1992 онд цөмийн зэвсэггүй бүсийн статустай болох Монгол Улсын санаачилгыг НҮБ-ын индэр дээрээс танилцуулж, холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэний үр дүнд 2012 онд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн гишүүн таван орон Монгол Улсын цөмийн зэвсэггүй бүс статусыг албан ёсоор баталгаажуулсан.

“Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 60 дугаар тогтоолоор Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцийн 2005 оны нэмэлт өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд тус тус нэгдэн орох талаар холбогдох арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан.

### **1. Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенц**

*Зорилго:* Олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар дэлхий дахинд цөмийн аюулгүй ажиллагааны дэглэмийг ханган тогтвортой байдлыг сахих, цөмийн төхөөрөмжөөс үүсэх ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хүн ам болон хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгоор болзошгүй цацрагийн ослын үед үр дүнтэй хариу арга хэмжээ төлөвлөх, хэрэгжүүлэх, цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд сөрөг үр дагаврыг багасгахад оршино.

*Нэгдэн орсон улс:* 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 91 орон нэгдэн орж, 65 улс гарын үсэг зурсан.

*Ач холбогдол:* Цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглахад цөмийн аюул болон цацрагийн сөрөг нөлөөллөөс хүн ам, нийгэм болон хүрээлэн буй орчныг үр ашигтай хамгаалах хяналтын тогтолцоо бий болох, шаардлагатай тохиолдолд олон улсын хамтын ажиллагааны хүрээнд техникийн дэмжлэг туслалцаа авах, цөмийн байгууламж бүхий орнуудын цөмийн байгууламжийн аюулгүй ажиллагааны талаарх тайланг хэлэлцэх хуралдаанд оролцох, хөрш зэргэлдээ орнуудын цөмийн байгууламжийн аюулгүй ажиллагааны талаарх тайлан мэдээллийг авч, хилийн ойр

байрлах цөмийн байгууламжийн эрсдэлд үнэлгээ хийх, хүн ам, байгаль орчныг хамгаалах, ослоос сэргийлэх, аюулгүй ажиллагааг сайжруулахад шаардлага тавина.

Конвенцын эх хувийг дараах холбоосоор татан авч үзнэ үү:

Монголоор хэл дээр: [Энд дарна уу](#)

English version: [Энд дарна уу](#)

## **2. Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай конвенц**

*Зорилго:* Нэгдэн орсон талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар дэлхий дахинд ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны соёлыг бий болгох, түүнийг дээд зэргээр хангах, бүх үе шатанд ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хүн ам, нийгэм болон хүрээлэн буй орчныг хамгаалах, цацрагийн сөрөг үр дагавар бүхий ослоос урьдчилан сэргийлэх, ослын хор уршгийг арилгахад оршино.

*Нэгдэн орсон улс:* 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар цөмийн эрчим хүчний хөтөлбөртэй болон хөтөлбөргүй 88 улс нэгдэн орж, 42 улс гарын үсэг зурсан.

*Ач холбогдол:* Энхийн зориулалтаар ашиглаж буй цөмийн реакторын ашигласан түлшний менежментийн аюулгүй ажиллагаа болон энхийн зориулалтын хэрэглээнээс үүсэх цацраг цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааг хангах, дотоодын хяналтын эрх зүйн орчныг сайжруулах, үйл ажиллагааг олон улсын хэм хэмжээ, шаардлагын дагуу хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Конвенцын эх хувийг дараах холбоосоор татан авч үзнэ үү:

Монгол хэл дээр: [Энд дарна уу](#)

English version: [Энд дарна уу](#)

## **3. Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын 2005 оны нэмэлт**

*Зорилго:* Энхийн зорилгоор ашиглаж буй цөмийн байгууламж, цөмийн материалыг дэлхий дахинд үр дүнтэй биечлэн хамгаалах тогтолцоог бий болгож хэвшүүлэх, энэхүү материал болон байгууламжийн эсрэг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, оролцогч улсуудын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино.

*Нэгдэн орсон улс:* 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 131 улс нэгдсэн орсон.

*Ач холбогдол:* Цөмийн материал болон цөмийн байгууламжийг биечлэн хамгаалалтыг олон улсын түвшинд хүргэх, цөмийн терроризм, гэмт хэрэгтэй тэмцэх, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх ба эдгээр зорилтуудад нийцсэн үндэсний эрх зүйн орчинг бий болгоно. Үндэсний аюулгүй байдлыг хангах, цөмийн террорист

үйлдлээс урьдчилан сэргийлэх, бодит аюул тулгарсан тохиолдолд Олон Улсын Атомын Энергийн Агентлагт нэн даруй мэдэгдэх, олон улсын байгууллагуудаас дэмжлэг авах боломж бүрдэнэ.

Конвенцын нэмэлтийн эх хувийг дараах холбоосоор татан авч үзнэ үү:

Монгол хэл дээр: [энд дарна уу](#)

English version: [энд дарна уу](#)

#### **4. Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол**

*Зорилго:* Бага хэмжээний цөмийн материалтай болон цөмийн төхөөрөмжгүй улс орнуудад цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааг хэрэгжүүлэх, үр дүнтэй хяналтыг бий болгоход оршино.

Протоколын эх хувийг дараах холбоосоор татан авч үзнэ үү:

Монгол хэл дээр: [энд дарна уу](#)

English version: [энд дарна уу](#)

*Нэгдэн орсон улс:* 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 57 улс протоколын шинэчилсэн хувилбарыг дагаж мөрдөж байна.

*Ач холбогдол:* Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааг хэрэгжүүлэх, улмаар цөмийн материалын ашиглалт, хэрэглээнд үр дүнтэй хяналт тавих, техникийн чадавхыг бэхжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, цөмийн материалын бүртгэл хяналтыг бэхжүүлэх чиглэлээр ОУАЭА-аас зөвлөх үйлчилгээ болон бусад дэмжлэгийг авна. Цөмийн материалын бүртгэл, хяналтыг олон улсын түвшинд хүргэнэ.

xxxXXXxxx